



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 20 (305)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*
- *"Олон улсын хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай конвенци"-д нэгдэн орох тухай*
- *Арбитрын тухай*
- *Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны тавдугаар сарын 28

№ 20 (305)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

285.	Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-5-8-ны хууль)	458
286.	"Олон улсын хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай конвенци"-д нэгдэн орох тухай	(2003-5-8-ны хууль)	458
287.	Арбитрын тухай	(2003-5-9-ний хууль)	458
288.	Гадаад худалдааны арбитрын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	(2003-5-9-ний хууль)	466
289.	Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай	(2003-5-9-ний хууль)	466

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

290.	Журам батлах тухай	Дугаар 13	467
291.	Журам батлах тухай	Дугаар 14	471
292.	"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн хилийн заагийг өөрчлөн батлах тухай	Дугаар 15	473

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

293.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 221	474
294.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 105	474
295.	Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай	Дугаар 106	474

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

296.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн заалт зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 01	475
------	--	-----------	-----

Тав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

297.	Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн "Зэвсэгт хүчний бүтэц" гэсэн ойлголтыг тайлбарлах тухай	Дугаар 04	480
------	---	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний нисэхийн тухай арилжааны нислэг үйлдэх бүх үйл ажиллагааг хуугийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг дор зохицуулна.
дурдсанаар өөрчлөн найруулсугай.

*4.2.Энэ хууль нь улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөн болон улсын агаарын хөлгөөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

"ОЛОН УЛСЫН ХООРОНДЫН АВТО ЗАМААР АЧАА ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ КОНВЕНЦИ"-Д НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Женев хотноо 1956 оны 5 соёрхон баталсугай.
дугаар сарын 19-ний өдөр баталсан "Олон улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай Конвенци"-д Монгол Улс нэгдэн орсныг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

АРБИТРЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой мэрганд арбитрын ажиллагаа явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Арбитрын тухай хууль тогтоомж

2.1. Арбитрын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль³, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль⁴, энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Маргаан шийдвэрлэх арбитр нь Монгол

Улсын нутаг дэвсгэрт ажиллагаа явуулах тохиолдолд энэ хууль үйлчилнэ.

3.2. Гадаадын арбитрын шийдвэрийг Монгол Улсад хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх ажиллагааг Гадаадын арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенц⁵ болон энэ хуулийн "НАЙМДУГААР БҮЛЭГ"-г зааснаар зохицуулна.

3.3. Монгол Улсын арбитрын шийдвэрийг гадаад улсад хүлээн зөвшөөрөх ба гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "байнгын арбитр" гэж арбитрын ажиллагааг байнга эрхлэн явуулах зорилгоор байгуулсан арбитрыг;

4.1.2. "түр арбитр" гэж талууд тодорхой маргааныг шийдвэрлүүлэх зорилгоор нэг удаа байгуулсан арбитрыг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмтлэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль – "Төрийн мэдээлэл" эмтлэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмтлэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмтлэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Олон Улсын конвенцид нэгдэн орох тухай Монгол Улсын хууль – "Төрийн мэдээлэл" эмтлэлийн 1994 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

4.1.3. "арбитрын ажиллагаа" гэж агуулын хооронд гарсан маргааныг арбитрын хэлэлцээр олон энэ хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх жиллагааг;

4.1.4. "арбитрын бүрэлдэхүүн" гэж ухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулж буй нэг үеү хэд хэдэн арбитрийг;

4.1.5. "арбитрч" гэж энэ хуульд заасан рх бүхий этгээдээс тухайн маргаанаар арбитрын жиллагаа явуулахаар томилогдсон хувь хүнийг;

4.1.6. "шүүх" гэж Шүүхийн тухай уулийн¹³ дугаар зүйлд заасан Монгол Улсын шүүхийн ндсэн тогтолцонд хамаарах байгууллагыг.

5 дугаар зүйл. Арбитрыг байгуулах

5.1. Арбитр нь байнгын болон түр хэлбэртэй айна.

5.2. Байнгын арбитрыг худалдаа аж үйлдвэрийн эхчим, үйлдвэрлэгчдийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг амгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн ус байгууллага, тэдгээрийн нэгдлийн дэргэд байгуулж олно.

5.3. Төрийн захиргааны байгууллага, засаг зиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, ашгийн элөө хуулийн этгээдийн дэргэд арбитр байгуулахыг зрилгоно.

5.4. Энэ хуулийн 5.2-т заасан байгууллага байнгын рбитр байгуулах тухай шийдвэр гаргаж, түүний дүрэм, шүүн арбитрчдын нэрсийн жагсаалтыг баталснаар хайн арбитрыг байгуулсанд тооцно.

5.5. Байнгын арбитрын удирдлага, зохион айгуулалтыг түүний дүрмээр тогтооно.

5.6. Байнгын арбитр нь энэ хуулийн 6 дугаар йлд заасан арбитрын харьяалагд хамаарах аль ч аргаанаар болон оюуны емчийн, гадаад арилжааны рхг тодорхой төрлийн маргаанаар арбитрын ажиллагааг энэн явуулж болно.

5.7. Түр арбитрыг маргагч талууд тухай бүр лнгээр тохиролцон байгуулна.

5.8. Байнгын болон түр арбитрын маргаан ийдвэрлэх ажиллагаа адил зөрчмөөр явагдана.

6 дугаар зүйл. Арбитрын харьяаллын маргаан

6.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хай хуулийн 13.2-т заасны дагуу талууд арбитраар ийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон маргаан ибитрын харьяалагд хамаарна.

7 дугаар зүйл. Арбитрын харьяалалд үл

хамаарах маргаан

7.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.3 болон шүүх, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар тусгайлан харьяалуулсан маргаан арбитрын харьяалалд үл хамаарна.

8 дугаар зүйл. Арбитрын ажиллагаанд дахь шүүхийн оролцоо

8.1. Энэ хуулийн 15.5-15.7, 17.4, 18.2, 20.6 дахь хэсэг, 13, 33, 40, 42, 43 дугаар зүйлд заасныг арбитрын ажиллагаа явагдаж байгаа газрын давж заалдах шатны шүүх, 12 дугаар зүйлд заасныг энх нэхэмжлэл хүлээж авсан шүүх өөрөө шийдвэрлэнэ.

8.2. Байнгын арбитр энэ хуулийн 15.5-15.7, 17.4, 18.2, 20.6-д шүүх шийдвэрлэхээр заасан маргааныг өөр этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн этгээдийн гаргасан шийдвэр эцсийн байна.

8.3. Шүүх энэ хуульд тусгайлан зааснаас бусад маргаанаар арбитрын ажиллагаанд оролцож үл болно.

9 дүгээр зүйл. Баримт бичиг хүргүүлэх

9.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол баримт бичгийг хүлээн авагч талд биеэр, эсхүл шуудангийн баталгаат илгээмжээр хүргүүлнэ. Шуудангаар хүргүүлэхдээ түүний өөрийн нь оршин суугаа, эсхүл ажилладаг байгууллагын нь хаягаар, эдгээр хаяг тодорхойгүй бол түүний хамгийн сүүлд мэдэгдэж байсан хаягаар явуулна. Ийнхүү хүргэсэн өдрийг уг баримт бичгийг хүлээн авсан өдөрт тооцно.

10 дугаар зүйл. Татгалзах эрхээсээ татгалзах

10.1. Талуудын аль нэг нь нөгөө талынхаа энэ хуулийн тодорхой заалтыг биелүүлэхээс зайлсхийж байгаа болон арбитрын хэлэлцээрийн аль нэг шаардлагыг биелүүлээгүйг мэдэж байсан атлаа энэ тухай нэн даруй татгалзал гаргалгүйгээр арбитрын ажиллагаанд оролцсон бол түүнийг татгалзах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Арбитрын хэлэлцээр

11 дүгээр зүйл. Арбитрын хэлэлцээрийн ойлголт, хэлбэр

11.1. Арбитрын хэлэлцээр гэж (гэрээний шянк, хэлбэр агуулсан эсэхээс үл хамааран) аль нэг эрх зүйн харилцаатай холбогдон үүссэн буюу үүсч болох бүх төрлийн, эсхүл тодорхой төрлийн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх талаар талуудын хооронд хийсэн тодорхой төрлийн хэлцлийг хэлнэ.

11.2. Арбитрын хэлэлцээрийг бичгийн хэлбэрээр хийх ба талууд уг хэлэлцээрийг маргаан гарахаас өмнө болон гарснаас хойш хэдийд ч хийж болно. Гэхдээ

¹³Уулийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эхтгэнийн 2002 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

Иргэний хуульд заасан стандарт нөхцөл бүхий гэрээний тухайд арбитрын хэлэлцээрийг гагцхүү маргаан үүссэний дараа хийнэ.

11.3. Талуудын гарын үсгээр баталгаажсан бие даасан арбитрын хэлэлцээр (гэрээний шинж, хэлбэр бүхий) болон арбитрын хэлэлцээр хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зорилгыг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс, эдгээртэй адилтгах бусад баримт бичиг арбитрын хэлэлцээрт хамаарна.

11.4. Талуудын хооронд байгуулсан үндсэн гэрээнд арбитрын хэлэлцээртэй холбоо бүхий ямар нэг баримт бичгийг иш татсан бөгөөд энэ нь тухайн гэрээний салшгүй хэсэг болохыг уг гэрээнд тусгайлан заасан бол үүнийг талуудын хооронд хийсэн бие даасан арбитрын хэлэлцээр гэж үзнэ.

11.5. Талуудын хооронд байгуулсан үндсэн гэрээ хүчин төгөлдөр эсэхээс үл хамааран түүний салшгүй хэсэг болох арбитрын хэлэлцээр хүчинтэй байна.

12 дугаар зүйл. Нэхэмжлэлийг арбитрт шилжүүлэх

12.1. Талууд тухайн маргаанаар шүүхэд эхэлж нэхэмжлэл гаргасан болон нэхэмжлэлийн шаардлагын талаар тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрт шилжүүлэх тухай хүсэлт гаргасан бөгөөд шүүх талуудын хооронд хийсэн арбитрын хэлэлцээр хүчинтэй бөгөөд хэрэгжих боломжтой гэж үзвэл уг маргааныг арбитрт шилжүүлнэ.

13 дугаар зүйл. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг шүүх баталгаажуулах

13.1. Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө буюу арбитрын ажиллагааны явцад талууд арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авчухааар давж заалдах шатны шүүхэд хүсэлт гаргаж болох бөгөөд шүүх уг хүсэлтийн дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан арга хэмжээ авч болох ба үүнийг арбитрын хэлэлцээртэй зөрчилдсөн гэж үзэхгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Арбитрын бүрэлдэхүүн, түүнийг бүрдүүлэх журам

14 дүгээр зүйл. Арбитрын бүрэлдэхүүн

14.1. Арбитрын бүрэлдэхүүн нэг буюу хэд хэдэн арбитрчаар бүрдэж болно.

14.2. Тухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулах арбитрчийн тоог талууд харилцан тохиролцно.

14.3. Хэрэв талууд арбитрчийн тоог харилцан тохиролцоогүй бол тухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулах арбитрчийн тоо гурав байна.

15 дугаар зүйл. Арбитрч томилох журам

15.1. Энэ хуульд заасан эрх бүхий этгээд хуулиар хориглосноос бусад хэний ч арбитрчаар томилж болно.

15.2. Дараахь этгээдийг арбитрчаар томилохыг хориглоно:

- 15.2.1. Үндсэн хуулийн Цэцгийн гишүүн;
- 15.2.2. шүүгч;
- 15.2.3. прокурор;
- 15.2.4. хэрэг бүртгэгч;
- 15.2.5. мөрдөн байцаагч;
- 15.2.6. шийдвэр гүйцэтгэгч;
- 15.2.7. тухайн маргаанаар талуудын аль нэгэнд урьд нь эрх зүйн үйлчилгээ үзүүлж байсан өмгөөлөгч, нотариатч;

15.2.8. хуулиар тогтоосон үүрэгт нь хамаарахгүй ажил, албан тушаал хавсрахыг хориглосон бусад албан тушаалтан.

15.3. Арбитрч томилох журмыг талууд харилцан тохиролцоо бөгөөд ингэхдээ энэ хуулийн 15.4-15.10-т заасныг баримтлана.

15.4. Арбитрч томилох журмыг талууд харилцан тохиролцоогүй буюу тохиролцсон боловч журмын дагуу тохиролцсон хүрч чадаагүй бол тухайн маргааныг шийдвэрлэх арбитрчийн тоо гурав байх ба талууд тус бүр нэг арбитрч томилж, томилогдсон хоёр арбитрч гурав дахь арбитрчийг тохиролцон томилох бөгөөд ийнхүү томилогдсон гурав дахь арбитрч арбитрын хуралдааныг даргална.

15.5. Аль нэг тал нь арбитрч томилох тухай нөгөө талын хүсэлтийг хүлээн авч аваас хойш 30 хоногийн дотор өөрийн талын арбитрчийг томилоогүй, эсхүл томилогдсон хоёр арбитрч 30 хоногийн дотор гурав дахь арбитрчийг тохиролцон томилж чадаагүй бол сонирхогч талын хүсэлтээр давж заалдах шатны шүүх тэдгэрийг томилно.

15.6. Талууд тухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулах арбитрчийн тоонг байцаар тогтоосон бол уг арбитрчийг харилцан тохиролцож томилох ба ийнхүү тохиролцож чадаагүй бол сонирхогч талын хүсэлтээр давж заалдах шатны шүүх түүнийг томилно.

15.7. Арбитрч томилох журмыг аль нэг тал зөрчсөн, эсхүл талууд тохиролцсон журмыхаа дагуу арбитрчийг томилж чадаагүй, түүнчлэн байнгын арбитрын дүрэмд заасан эрх бүхий этгээд арбитрч томилох үүргээ биелүүлээгүй бол энэ талаар шаардлагатай арга хэмжээ авахуулахаар сонирхогч тал давж заалдах шатны шүүхэд хүсэлт гаргаж болно.

15.8. Энэ хуулийн 15.5-15.7-д заасан маргаантай асуудлаар гаргасан давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.

15.9. Давж заалдах шатны шүүх арбитрч томилохдоо дараахь зүйлийг үндэслэл болгоно:

15.9.1. тухайн этгээд энэ хуульд заасны дагуу арбитрчаар томилогдох боломжтой эсэх;

15.9.2. маргааныг бие даан, харз



хуулар шийдвэрлэх чадвартай;

15.9.3. тухайн этгээд талуудын охиорлцсон шалгуурыг хангаж буй эсэх.

15.10. Талууд болон байнгын арбитрын дүрэмд заасан арбитрч томилох эрх бүхий этгээд арбитрч омилохдоо энэ хуулийн 15.9-д заасныг нэгэн адил гэримлэнэ.

16 дугаар зүйл. Татгалзах үндэслэл

16.1. Арбитрчаар ажиллах хүсэлт хүлээн авсан этгээд тухайн маргааныг бие даан, хараат бусаар шийдвэрлэж чадах эсэх талаар өөрт нь үндэслэл бүхий эргэлзэж байвал энэ тухайгаа хүсэлт тавьсан талд нэн даруй мэдэгдэнэ.

16.2. Арбитрчаар томилогдсоны дараа буюу арбитрын ажиллагааны явцад тухайн маргааныг бие даан, хараат бусаар шийдвэрлэж чадах эсэхэд нь эргэлзээ өрүүлэхүйц нөхцөл байдал бий болбол тухайн арбитрч талуудад энэ тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

16.3. Талууд арбитрчийг галзруу тухайн маргааныг бие даан, хараат бусаар шийдвэрлэж чадах эсэхэд нь эргэлзээ төрүүлэхүйц илэрхий нөхцөл байдал бий болсон охиолдолд татгалзан гаргаж болно. Бодитойгоор бий олон нөхцөл нь шийдвэр гаргах үндэслэл болно.

16.4. Талууд өөрийн томилсон буюу томилоход нь оролцсон арбитрчийг зөвхөн томилогдсоных нь дараа атгалзан гаргана.

17 дугаар зүйл. Татгалзан гаргах журам

17.1. Арбитрчийг татгалзан гаргах журмыг талууд эрилцэн тохиролцох бөгөөд ингэхдээ энэ хуулийн 17.4-заасныг баримтлана.

17.2. Арбитрчийг татгалзан гаргах журмыг талууд эрилцэн тохиролцоогүй буюу тохиролцсон боловч уг журмын дагуу арбитрчийг татгалзан гаргаж чадаагүй бол энэ хуулийн 16.3-т заасан нөхцөл байдал илэрснийг тэмдэглэж буюу эсхүл тухайн маргаанаар ажиллагаа вуулах арбитрын бүрэлдэхүүн бүрэн бүрдсэнийг тэдснээс хойш 15 хоногийн дотор арбитрчийг татгалзан эрхэх тухай хүсэлтийг сонирхогч тал уг арбитрын бүрэлдэхүүнд бичгээр гаргана.

17.3. Арбитрч байхаас өөрөө санаачилгаараа атгалзаж, талууд үүнийг нь зөвшөөрснөөс бусад охиолдолд арбитрчийг татгалзан гаргах эсэх асуудлыг эгцхүү тухайн арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

17.4. Талуудын тохиролцсон журам болон энэ хуулийн 17.2, 17.3-т заасны дагуу арбитрчийг татгалзан эрхэх чадаагүй бол сонирхогч тал тухайн арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг хүлээж авснаас хойш 30 өнгийн дотор давж заалдах шатны шүүх болон байнгын арбитрын дүрэмд заасан эрх бүхий этгээдэд энэ тухай хүсэлт гаргаж болно.

17.5. Энэ хуулийн 17.4-т заасан маргаантай талуудаар гаргасан эрх бүхий этгээдийн шийдвэр эцсийн байна.

17.6. Арбитрчийг татгалзан гаргах тухай сонирхогч талын гаргасан хүсэлтийг энэ хуулийн 17.4-т заасан эрх бүхий этгээд шийдвэрлэх хүртэл арбитрын бүрэлдэхүүнд уг арбитрч хэвээр байж арбитрын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж болно.

18 дугаар зүйл. Арбитрч үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болох

18.1. Арбитрч алив бодит шалтгааны улмаас үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болсон, эсхүл арбитрч байхаас өөрөө санаачилгаараа татгалзаж, талууд үүнийг нь зөвшөөрсөн бол уг арбитрчийн тухайн маргаанаар ажиллагаа явуулахтай холбоотой эрх, үүрэг дуусгавар болно.

18.2. Энэ хуулийн 18.1-д заасан асуудлаар үүссэн маргааныг давж заалдах шатны шүүх болон байнгын арбитрын дүрэмд заасан эрх бүхий этгээд шийдвэрлэж ба тухайн шийдвэр эцсийн байна.

19 дүгээр зүйл. Арбитрч нөхөн томилох

19.1. Энэ хуулийн 18.1-д заасан үндэслэлээр эрх, үүрэг нь дуусгавар болсон арбитрчийн оронд шинэ арбитрч нөхөн томилоход энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээ

20 дугаар зүйл. Маргааны харьяалал тогтоох эрх

20.1. Тухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулах арбитрын бүрэлдэхүүн уг маргааныг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан арбитрын харьяаллын маргаан мөн эсэхийг өөрөө тогтооно.

20.2. Арбитрын бүрэлдэхүүн нь талууд арбитрын хэлэлцэртэй эсэх, тухайн хэлэлцээр хүчинтэй эсэхийг тогтоох бөгөөд ингэхдээ энэ хуулийн 11.4, 11.5-д заасныг мөрдлөг болгоно.

20.3. Талууд маргааны харьяаллын талаар гомдол гаргахаар бол үндсэн нэхэмжлэлд тайлбар гаргахаасаа өмнө тухайн арбитрын бүрэлдэхүүнд уг гомдлыг гаргана.

20.4. Талууд арбитрын ажиллагааны явцад арбитрын бүрэлдэхүүн эрх хэмжээгээ хэтрүүлж байна гэж үзвэл энэ тухай гомдлыг нэн даруй тухайн арбитрын бүрэлдэхүүнд өөрт нь гаргана.

20.5. Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 20.3, 20.4-т заасан гомдлын талаар урьдчилан шийдвэр гаргах, эсхүл энэ тухай үндсэн шийдвэртээ тусгана.

20.6. Талууд энэ хуулийн 20.5-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болох ба тухайн шүүхийн шийдвэр эцсийн байна.

20.7. Давж заагдах шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж болно.

21 дүгээр зүйл. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг арбитрын бүрэлдэхүүн баталгаажуулах

21.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бөгөөд арбитрын бүрэлдэхүүн тухайн маргааны хувьд шаардлагатай гэж үзвэл аль нэг талын хүсэлтийг үндэслэн арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор зохих арга хэмжээ авахыг талуудад үүрэг болгож болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Арбитрын ажиллагаа

22 дугаар зүйл. Талуудын тэгш байдал

22.1. Талууд арбитрын ажиллагаанд тэгш эрхтэй оролцох ба нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, мэдүүлэг, холбогдох бусад нотлох баримтын талаар тайлбар хийх боломжоор бүрэн хангагдсан байна.

23 дугаар зүйл. Арбитрын ажиллагаа явуулах журмыг тодорхойлох

23.1. Арбитрын ажиллагаа явуулах журмыг талууд энэ хуульд нийцүүлэн харилцан тохиролцоно.

23.2. Арбитрын ажиллагаа явуулах журмыг талууд харилцан тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн холбогдох заалтыг баримтлан аль тохиромжтой гэж үзсэн журмаар арбитрын ажиллагааг явуулна.

24 дүгээр зүйл. Арбитрын ажиллагаа явуулах газар

24.1. Арбитрын ажиллагаа явуулах газрыг талууд харилцан тохиролцоно.

24.2. Арбитрын ажиллагаа явуулах газрыг талууд харилцан тохиролцоогүй бол маргааны нөхцөл байдлыг харгалзан арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагаа явуулах газраа тодорхойлно.

24.3. Талууд өөрөөр тохиролцоогүй бол шаардлагатай тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн зөвлөгдөх, гэрч, шинжээч, талуудын мэдүүлгийг сонсох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзэл шалгалт хийх зэрэг ажиллагааг арбитрын ажиллагаа явуулах газраас өөр газар явуулж болно.

25 дугаар зүйл. Арбитрын ажиллагаа эхлэх

25.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол тухайн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тухай нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хариуцагч тал хүлээн авсан өдрөөс арбитрын ажиллагаа эхэлнэ.

26 дугаар зүйл. Арбитрын ажиллагаа явуулах хэл

26.1. Арбитрын ажиллагааг монгол хэлээр явуулна.

26.2. Талууд өөрөөр тохиролцсон бол арбитрын ажиллагааг монгол хэлээс өөр хэлээр явуулж болно.

26.3. Арбитрын ажиллагааг явуулах хэлний талаар талууд тусгайлан өөрөөр тохиролцоогүй бол тухайн хэлээр арбитрын ажиллагааг данан явуулна.

26.4. Арбитрын бүрэлдэхүүн аливаа нотлох баримтыг арбитрын ажиллагааг явуулах хэлрүү орнуулж, хавсаргахыг талуудаас шаардаж болно.

27 дугаар зүйл. Нэхэмжлэгчийн нэхэмжлэл ба хариуцагчийн тайлбар

27.1. Нэхэмжлэлийг арбитрт бичгээр гаргах бөгөөд түүнд нэхэмжлэгч, эсхүл арбитрын ажиллагаанд түүнийг төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна.

27.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэхэмжлэлийн бүрдүүлбэр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасантай нэгэн адил байна.

27.3. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, зөлрөх, эсхүл хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй.

27.4. Нэхэмжлэлийн шаардлагад хариуцагч энэ хуулийн 27.3-т заасан аль нэг үндэслэлээр бичгээр тайлбар гаргаж, арбитрт өгнө.

27.5. Нэхэмжлэлийн шаардлага болон хариуцагчийн тайлбарт шаардлагатай гэж үзсэн бүх баримт бичгийг хавсаргах ба тэдгээрийг тайлбарласан буюу нотолсон баримтыг нэмж оруулж болно.

27.6. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлага болон хариуцагчийн тайлбарт талууд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

28 дугаар зүйл. Арбитрын бүрэлдэхүүн зохигчдын тайлбарыг сонсох, эсхүл сонсохгүйгээр нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргах

28.1. Тухайн маргааныг цугларсан нотлох баримтад үндэслэн шийдвэрлэх, эсхүл зохигчид холбогдох нотлох баримтыг амаар танилцуулж шийдвэрлүүлэх талаар талууд тусгайлан тохиролцоогүй бол хэрэг шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулахыг арбитрын бүрэлдэхүүн өөрөө тогтооно.

28.2. Талууд маргааныг цугларсан нотлох баримтад үндэслэн шийдвэрлэхээр тохиролцсон боловч аль нэг тал нь хүсэлт гаргавал арбитрын бүрэлдэхүүн талуудад нотлох баримтыг амаар тайлбарлаж, мэтгэгцэж боломжийг олгоно.



28.3. Арбитрын бүрэлдэхүүн бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзлэг хийх бол энэ тухай боломжтой хугацааны өмнө талуудад заавал мэдэгдэх үүрэгтэй.

28.4. Арбитрын бүрэлдэхүүнд гаргаж буй маргаанд холбогдох баримт бичиг, бусад мэдээллийг талууд өөр хоорондоо заавал хүргүүлнэ.

28.5. Арбитрын шийдвэр гаргахад ашиглаж буй шинжээчийн дүгнэлт, нотолгооны шиеэктэй бусад баримт бичгийг арбитрын бүрэлдэхүүн талуудад мөн нэгэн адил хүргүүлнэ.

29 дүгээр зүйл. Талууд үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагавар

29.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бөгөөд тэдгээрийн үүргээ биелүүлээгүй явдлыг хүндэтгэн үзэх шалтгаангүй гэж үзвэл арбитрын бүрэлдэхүүн дараахь арга хэмжээ авч болно:

29.1.1. гаргасан нэхэмжлэл нь энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл арбитрын ажиллагааг зогсоох;

29.1.2. хариуцагчийн тайлбар энэ хуульд заасан шаардлага хангасан эсэхийг үл харгалзан арбитрын ажиллагааг үргэжлүүлэн явуулах;

29.1.3. аль нэг тал нь арбитрын хуралд оролцоогүй буюу эсхүл шаардлагатай нотлох баримтыг ирүүлээгүй бол арбитрын ажиллагааг үргэжлүүлж, цугларсан нотлох баримтад үндэслэн арбитрын шийдвэр гаргах.

30 дугаар зүйл. Шинжээч томилох

30.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол тодорхой асуудлаар дүгнэлт гаргуулахаар арбитрын бүрэлдэхүүн нэг, эсхүл хэд хэдэн шинжээч томилж болно.

30.2. Арбитрын бүрэлдэхүүн тухайн маргаанд холбогдох мэдээллийг шинжээчид гаргаж өгөх, бараа бүтээгдэхүүн, бусад эд хөрөнгө, баримт бичигт үзлэг шалгалт хийх боломжийг шинжээчид олгохыг талуудаас шаардаж болно.

30.3. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүний болон аль нэг талын хүсэлтээр шинжээч арбитрын хуралдаанд оролцож, гаргасан дүгнэлтийнхээ талаар тайлбар хийж, зохигчдын тавьсан асуултад хариулт өгөх үүрэгтэй.

31 дүгээр зүйл. Бусдаас тусламж авах

31.1. Зохигчид арбитрын ажиллагаа явуулах хэлийг мэдэхгүй, эсхүл хэлгүй, дүлий шалтгааны улмаас тухайн хэл, бичгээр харилцаж чадахгүй, түүнчлэн тэдгээрт мэргэжлийн болон бусад тусалцаа шаардлагатай бол холбогдох этгээд (орчуулагч, хэлмэрч, өмгөөлөгч, төлөөлөгч зэрэг)-ээс тусламж авч болно.

31.2. Талууд бусдаас авсан тусламж, үйлчилгээнийхээ хөлсийг тусалцаа үзүүлсэн этгээдэд

өөрт нь шууд, эсхүл тухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулж буй арбитрын бүрэлдэхүүнд төлнө.

32 дугаар зүйл. Нууц хадгалах

32.1. Арбитрын бүрэлдэхүүн болон зохигчид арбитрын ажиллагааны явцад тодорхой болсон төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах үүрэгтэй.

33 дугаар зүйл. Нотлох баримт бүрдүүлэхэд шүүх тусалцаа үзүүлэх

33.1. Арбитрын бүрэлдэхүүн, эсхүл түүний зөвшөөрснөөр аль нэг тал тухайн маргаантай холбоотой нотлох баримт гаргуулахаар давж заалдах шалтны шүүхэд хүсэлт гаргаж болох бөгөөд шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд уг хүсэлтийг биелүүлнэ.

ЗУРГАДГААР БҮЛЭГ

Арбитрын шийдвэр гаргах, арбитрын ажиллагаа дуусгавар болох

34 дүгээр зүйл. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ

34.1. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээг талууд харилцан тохиролцоо бөгөөд арбитрын бүрэлдэхүүн тэдгээрийн тохиролцсон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн уг маргааныг шийдвэрлэнэ.

34.2. Арбитрын бүрэлдэхүүн талуудын тохиролцсон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхдээ уг тохиролцоонд тусгайлан заагаагүй бол түүнийг тухайн улсын материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэж ойлгож хэрэглэнэ.

34.3. Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээг талууд харилцан тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн тухайн маргааныг шийдвэрлэхэд аль тохиромжтой гэж үзсэн зохих материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэнэ.

34.4. Арбитрын бүрэлдэхүүн аливаа маргааныг шийдвэрлэхдээ талуудын хооронд байгуулсан үндсэн гэрээ болон тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан үзнэ.

35 дугаар зүйл. Арбитрын шийдвэр

35.1. Арбитрын бүрэлдэхүүнээс гаргасан шийдвэрийг тухайн арбитрын шийдвэр гэж үзэх ба талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн шийдвэрээ олонхийн саналгаар гаргана.

35.2. Арбитрын бүрэлдэхүүн санал нэгтэй зөвшөөрсөн бол арбитрын ажиллагааны явцад гарах горимын шинжтэй асуудлыг арбитрын хуралдаан даргалагч дангаараа шийдэж болно.



36 дугаар зүйл. Талууд эвлэрэх

гэж үзсэн;

36.1. Арбитрын ажиллагааны явцад талууд эвлэрвэл арбитрын ажиллагааг дуусгавар болгож, эвлэрлийн нөхцөлийг арбитрын шийдвэрт тусгаж баталгаажуулна.

38.2.4. талууд энэ хуулийн 41.6-д заасан арбитрын зардлыг тохиролцсон хугацаанд төлөөгүй.

36.2. Энэ хуулийн 36.1-д заасны дагуу гаргасан арбитрын шийдвэрт энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан шаардлага нэгэн адил хамаарах ба уг шийдвэр нь арбитрын үндсэн шийдвэртэй адил хүчин чадалтай байна.

38.3. Нэхэмжлэгч нэхэмжлэгээсээ татгалзсан боловч хариуцагч маргааныг арбитраар эцэслэн шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргаж, түүнийг арбитрын бүрэлдэхүүн хүлээн авсан бол арбитрын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж эцсийн шийдвэр гаргана.

38.4. Арбитрын ажиллагаа дуусгавар болоноор тухайн арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээ дуусгавар болж ба гагцхүү энэ хуулийн 39 дүгээр зүйл, 40.4-т заасан ажиллагааг явуулж болно.

37 дугаар зүйл. Арбитрын шийдвэрийн хэлбэр, агуулга

39 дүгээр зүйл. Арбитрын шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах

37.1. Арбитрын шийдвэрийг бичгээр гаргах бөгөөд түүнд арбитрч гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

37.2. Хэд хэдэн арбитрч бүхий арбитрын бүрэлдэхүүнээс гаргах шийдвэрийн тухайд тэдгээрийн олонхи гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба хэрэв аль нэг арбитрч гарын үсэг зураагүй бол шалтгааныг нь дурдана.

39.1. Талууд өөр хугацаа тогтоогоогүй бол арбитрын шийдвэрийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор үг үсэг, тооцоо, хэвлэлийн болон тэдгээртэй адилтгах бусад алдааг засуулах тухай хүсэлтийг аль нэг тал гаргаж болох бөгөөд энэ тухайгаа нөгөө талдаа заавал мэдэгдэнэ.

37.3. Арбитрын шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

39.2. Энэ хуульд зааснаас өөр үндэслэлээр арбитрын шийдвэрт засвар оруулах хүсэлт гаргаж болохгүй бөгөөд тийм хүсэлт гаргасан бол арбитрын бүрэлдэхүүн болон шүүх авч хэлэлцэхгүй.

37.3.1. арбитрын бүрэлдэхүүн, эсхүл маргааныг дангаараа шийдвэрлэсэн арбитрийн нэр, шийдвэр гаргасан газар, огноо;

39.3. Талууд өөр хугацаа тогтоогоогүй бол арбитрын шийдвэрийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор түүнийг тодорхой заалт, хэсгийг тайлбарлуулах тухай хүсэлтийг аль нэг тал арбитрын бүрэлдэхүүнд гаргаж болох бөгөөд энэ тухайгаа нөгөө талдаа заавал мэдэгдэнэ.

37.3.2. талууд өөрөөр тохиролцсон буюу эвлэрснээс бусад тохиолдолд арбитрын шийдвэрийн хууль зүйн үндэслэл;

39.4. Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 39.1, 39.3-т заасан хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитрын шийдвэрт зохих засвар оруулах буюу холбогдох тайлбар хийх бөгөөд тайлбар нь арбитрын шийдвэрийн бүрэлдэхүүн хэсэг болно.

37.3.3. арбитрын зардал.

37.4. Арбитрын шийдвэрийг талуудад заавал хүргүүлнэ.

39.5. Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 39.1-д заасан алдааг шийдвэр гаргаснаас хойш 30 хоногийн дотор өөрийн санаачилгаар засч болно.

37.5. Арбитрын шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа талууд, эсхүл тэдгээрийн эрх залгамжлагчид тухайн маргаанаар шүүх болон арбитрт нэхэмжлэл гаргах эрхгүй.

39.6. Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын ажиллагааны явцад хэлэлцсэн боловч арбитрын шийдвэрт тусгагдаагүй орхигдсон нэхэмжлэлийн шаардлагын талаар нэмэлт шийдвэр гаргахыг үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор аль нэг тал нь шаардаж болох бөгөөд энэ тухайгаа нөгөө талдаа заавал мэдэгдэнэ.

38 дугаар зүйл. Арбитрын ажиллагаа дуусгавар болох

38.1. Арбитрын үндсэн шийдвэр болон энэ хуулийн 38.2-т заасан шийдвэр гарснаар арбитрын ажиллагаа дуусгавар болно.

39.7. Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 39.6-д заасан шаардлагыг үндэслэлтэй гэж үзвэл түүнийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор нэмэлт шийдвэр гаргана.

38.2. Арбитрын бүрэлдэхүүн дараахь тохиолдолд арбитрын ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргана:

38.2.1. нэхэмжлэгч нэхэмжлэгээсээ татгалзсан;

38.2.2. арбитрын ажиллагааг дуусгавар болгохоор талууд харилцан тохиролцсон;

39.8. Арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 39.4, 39.7-д заасан хугацааг сунгаж болно.

38.2.3. арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагагүй буюу боломжгүй



39.9. Арбитрын шийдвэрт засвар оруулах, тайлбар хийх болон нэмэлт шийдвэр гаргахад энэ хуулийн 37 дугаар зүйл нэг адил хамаарна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлт гаргах

40 дүгээр зүйл. Шийдвэр хүчингүй болгох тухай хүсэлт гаргах

40.1. Талууд гэлцүү энэ хуулийн 40.2-т заасан үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг арбитрын ажиллагаа явагдсан газрын давж заалдах шатны шүүхэд гаргаж болно.

40.2. Давж заалдах шатны шүүх зөвхөн дор дурдсан тохиолдолд арбитрын шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй:

40.2.1. арбитрын хэлэлцэрийн аль нэг тал эрх зүйн чадвар, чадмжгүй байсан, эсхүл арбитрын хэлэлцээрт хэрэглэхээр тохиролцсон улсын хуулийн дагуу, хэрэв ийнхүү тохиролцоогүй бол Монгол Улсын хуулийн дагуу тухайн арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус болсон;

40.2.2. арбитрч томилох тухай болон арбитрын ажиллагааны талаар арбитрын бүрэлдэхүүн талуудад зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, мэдүүлэг, холбогдох бусад нотлох баримтын талаар тайлбар хийх боломжоор тэднийг хангаагүй;

40.2.3. арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлж болон арбитрын бусад ажиллагаа явуулах талаар талуудын тохиролцсон журмыг тухайн арбитрын бүрэлдэхүүн зөрчсөн;

40.2.4. арбитрын бүрэлдэхүүн арбитрын хэлэлцээрт хамсааралгүй асуудлаар шийдвэр гаргасан, түүнчлэн уг шийдвэрт заасан арбитрт хамсааралгүй хэсгийг шийдвэрийн бусад заалтаас салгаж хүчингүй болгох боломжгүй;

40.2.5. тухайн маргаан нь арбитрын харьяаллын маргаан биш болох нь нотлогдсон;

40.2.6. тухайн арбитрын шийдвэр Монгол улсын нийтлэг ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд харшигтаар бол.

40.3. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох хүсэлтийг уг шийдвэрийг хүлээж авснаас хойш гурван сарын дотор гаргаж болох бөгөөд хэрэв талууд энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан үндэслэлээр арбитрын бүрэлдэхүүнд хүсэлт гаргасан бол уг хүсэлтийг шийдвэрлэснээс хойш энэхүү хугацааг тооцно.

40.4. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох зөрчил гарсан бөгөөд түүнийг арбитрын бүрэлдэхүүнээр өөрөөр нь засуулах хүсэлтийг аль нэг тал гаргасан бол давж заалдах шатны шүүх арбитрын шийдвэрийг хянах

ажиллагааг тодорхой хугацаа тогтоон түдгэлзүүлж болно.

40.5. Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 40.4-т заасны дагуу давж заалдах шатны шүүхээс тогтоосон хугацаанд зөрчлийг засаагүй бол давж заалдах шатны шүүх түдгэлзүүлсэн шийдвэрээ хүчингүй болгож, давж заалдсан гомдлыг хэлэлцэн шийдвэр гаргана.

41 дүгээр зүйл. Арбитрын ажиллагааны зардал

41.1. Тухайн маргааны шөнг байдал, ажиллагаа явуулахад шаардагдах хугацаа зэргийг харгалзан арбитрын ажиллагаа явуулахад шаардлагатай зардлын хэмжээг арбитрын бүрэлдэхүүн төлөвлөнө.

41.2. Арбитрын ажиллагааны явцад гарсан бодит зардлыг арбитрын бүрэлдэхүүн тогтоож, энэ талаар арбитрын шийдвэрт заавал тусгана.

41.3. Арбитрын зардалд дараахь зүйл хамаарна:

41.3.1. арбитр-ийн хөлс;
41.3.2. арбитрын ажиллагааны явцад арбитрчаас гарсан зардал;

41.3.3. энэ хуулийн 31.2-т заасан төлөгдөөгүй зардал;
41.3.4. гэрчтэй холбогдон гарсан зардал;

41.3.5. арбитрын ажиллагааны явцад арбитрын бүрэлдэхүүнээс гарсан бусад зардал;

41.3.6. байнгын арбитрын хувьд түүний дүрмэд заасны дагуу тухайн арбитрт төлөг үйлчилгээний хөлс.

41.4. Талууд өөр хоорондоо болон арбитрын бүрэлдэхүүнтэй өөрөөр тохиролцоогүй бол нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд арбитрын зардлыг хариуцагчаар, нэхэмжлэлийг хэргэсэхгүй болгосон бол уг зардлыг нэхэмжлэгчээр, хэсэгчлэн хангасан бол хувь тэнцүүлж төлүүлнэ.

41.5. Арбитрын шийдвэр гархаас өмнө талууд эвлэрсэн буюу нэхэмжлэгч нэхэмжлэгчээс татгалзсан, эсхүл хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан, түүнчлэн маргааныг нэг арбитрч шийдвэрлэсэн зэргээс шалтгаалан арбитрын ажиллагаанд төлөвлөсөн зардалаас бодит зардал бага гарвал зөргүү арбитрын бүрэлдэхүүн талуудад буцаан олгоно.

41.6. Арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааны зардлыг талуудаас урьдчилан авч болно.

41.7. Талуудаас урьдчилан авах арбитрын ажиллагааны зардлын хэмжээг арбитрын бүрэлдэхүүн тогтоох бөгөөд талууд тохиролцсон хугацаанд уг зардлыг төлөөгүй бол энэ нь арбитрын ажиллагааг түдгэлзүүлэх буюу дуусгавар болгох үндэслэл болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх

42 дугаар зүйл. Арбитрын шийдвэрийг

Баталгаажуулах, гүйцэтгэх

42.1. Арбитрын шийдвэрийг холбогдох тал заавал биелүүлэх үүрэгтэй.

42.2. Арбитрын шийдвэрийг холбогдох тал биелүүлээгүй бол нөгөө тал нь уг шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар гүйцэтгүүлэхээр давж заалдах шатны шүүхэд хүсэлт гаргаж болно.

42.3. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 42.2-т заасан хүсэлтийг шүүхэд гаргах хөөн хэлэлцэх хугацаа тухайн арбитрын шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 жил байна.

42.4. Гадаадын арбитрын шийдвэрийг Монгол Улсад гүйцэтгүүлэх тухай шүүхэд хүсэлт гаргах хугацаа энэ хуулийн 42.3-д заасантай адил байна.

42.5. Арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлт гаргасан тал уг хүсэлтэд арбитрын шийдвэр болон арбитрын хэлэлцээрийн эх хувь, эсхүл түүний зөвхөн журмын дагуу /тухайн арбитрын шийдвэр гарсан улсын хуулийн дагуу/ гэрчилсэн хуулбарыг хавсаргана.

42.6. Гадаад хэлээр бичигдсэн арбитрын шийдвэр, арбитрын хэлэлцээрийг монгол хэл дээр орчуулж, гэрчилсэн арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлтэд хавсаргана.

42.7. Давж заалдах шатны шүүх арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл тухайн арбитрын шийдвэрийг баталгаажуулж, Иргэний хэрэг шүүхэд ялан шийдвэрлэх тухай хуулийн 184.3-т заасан гүйцэтгэх хуудас бичнэ.

42.8. Энэ хуулийн 37.1, 37.2, 39 дүгээр зүйлд заасан хүчин төгөлдөр болсон арбитрын шийдвэр, тэдгээрийн үндсэн дээр шүүхээс олгосон гүйцэтгэх хуудас нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах үндэслэл болох бөгөөд түүний утга агуулгыг өөрчилсөн буюу гүйвуулсан аливаа бичиг баримтыг хууль ёсны бус гэж үзнэ.

42.9. Давж заалдах шатны шүүх хууль зүйн үндэслэлгүйгээр, эсхүл тодорхой бус шалтгаанаар гүйцэтгэх хуудас бичээгүй нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулахгүй байх үндэслэл болохгүй бөгөөд энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэх ажиллагааг өөрийн санаачилгаар явуулна.

43 дугаар зүйл. Арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэхээс татгалзах

43.1. Давж заалдах шатны шүүх зөвхөн дор дурдсан тохиолдолд арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэх хуудас бичнээс татгалзах эрхтэй:

43.1.1. Энэ хуулийн 40.2-т заасан нөхцөл байдал тогтоогдох;

43.1.2. Арбитрын шийдвэр талуудын хувьд хүчин төгөлдөр болоогүй байгаа буюу арбитрын шийдвэр гаргасан улсын шүүх тухайн шийдвэрийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон.

МОНГОЛУЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

ГАДААД ХУДАЛДААНЫ АРБИТРЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Гадаад худалдааны арбитрын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арбитрын тухай

хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд дор дурдсан агуулгатай 6' дүгээр зүйл нэмсүгэй:

6' дүгээр зүйл. Шүүхээс арбитрын ажиллагаанд оролцсоны хураамжийн хэмжээ

1. Арбитрын ажиллагаанд шүүх оролцоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/ арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлт шийдвэрлэхэд нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0,1 хувь;

2/ арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгүүлэх тухай хүсэлт шийдвэрлэхэд нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0,1 хувь;

3/ Арбитрын тухай хуульд заасан бусад асуудлаар шийдвэр гаргахад нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0,05 хувиар."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арбитрын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛУЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 35.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасан төрийн

өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн болон мөн хуулийн 16.2.14-т заасан төсвийн бусад байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх удирдах албан тушаалтан/дарга, захирал, эрхлэгч/-ыг сонгон шалгаруулах журмыг батлан мөрдүүлэхийг Төрийн албаны зөвлөлд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ УДИРДАХ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай алба (цаашид "Төрийн жинхэнэ алба" гэх)-ны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг баримтлана.

2. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд төрийн захиргааны болон төрийн тусгай албаны зорилт, чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, түүнээс дээшхи бусад албан тушаал хамаарна.

3. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаал /цаашид "удирдах албан тушаал" гэх/-д томилогдох ажилтныг сонгон шалгаруулах ажлын зорилго нь Төрийн албаны тухай хуулийн 10.1, 10.3, 10.4, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 5.1.3-т заасан болон тухайн албан тушаал (ажлын байр)-д тавигдах шаардлагыг хангасан, төрийн албаны зорилт, чиг үүргийг мэргэшлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх удирдах ажилтныг шилж сонгоход оршино.

4. Удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахдаа хууль дээдлэх, шударга, ил тод байх, адил тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

5. Төрийн албаны тухай хуулийн 16.1-д заасны дагуу удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахад үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад

байгууллагын харъяалал зэргээр ялгаварлаж болохгүй.

6. Төрийн жинхэнэ албан тушаалд тавих ерөнхий болон тусгай шаардлага, ёс зүйн хэм хэмжээ, Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол хангасан Монгол Улсын иргэн сонгон шалгаруулалтад орно.

7. Төрийн жинхэнэ албанд анх орох иргэн Төрийн албаны тухай хуулийн 16.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтад орохгүй.

8. Сонгон шалгаруулалттай холбогдож гарах зардлыг тухайн төрийн байгууллага жил бүр төсөвтөө тусгасан байна.

Хоёр. Сонгон шалгаруулалтад хамрагдах албан тушаалтан

9. Төрийн албаны зөвлөл нь дор дурдсан удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулна:

а) Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1.1-45.1.7-д заасан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын ажлын албаны дарга болон хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлагийн дарга, Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга зэрэг ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх албан тушаалтан;



б/дор дурдсан байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн болон энэ журмын 9-ийн "а"-д зааснаас бусад удирдах албан тушаалтан:

- 1/Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар;
- 2/Улсын Их Хурлын Тамгын газар;
- 3/Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
- 4/Үндсэн хуулийн цэц;
- 5/Улсын дээд шүүх;
- 6/Улсын ерөнхий прокурорын газар;
- 7/Яам /хэлтэс, алба, тасгийн дарга хамаарахгүй/;
- 8/Шүүхийн ерөнхий зөвлөл;
- 9/хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллага.

в/Засгийн газрын тохируулагч агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжээс дээшхи, энэ журмын 9-ийн "а"-д зааснаас бусад удирдах албан тушаалтан;

г/Улаанбаатар хотын Ерөнхий менежер, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргаас дээшхи удирдах албан тушаалтан болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга.

10.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл /цаашид "Салбар зөвлөл" гэх/ нь энэ журмын 9-д зааснаас бусад удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулна.

Гурав. Удирдах албан тушаалд томилогдох ажилтны сул орон тооны захиалга ирүүлэх

11.Томилох эрх бүхий этгээд нь энэ журмын 9-ийн "а"-д заасан удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн албан тушаалд ажиллах удирдах ажилтныг сонгон шалгаруулах захиалгыг ажлын байрны тодорхойлолтын хамт Төрийн албаны зөвлөлд ирүүлнэ.

12.Удирдах албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтыг томилж эрх бүхий этгээд баталсан байна.

13.Албан тушаалын тодорхойлолтод тухайн албан тушаалын зорилго, зорилт, гүйцэтгэх чиг үүрэг, хүлээх хариуцлага болон дор дурдсан шалгуурыг хангасан байдлыг тусгасан байна.

- 1/Тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг;
- 2/Боловсролын түвшин;
- 3/Мэргэжил;
- 4/Ажлын туршлага, мэргэшлийн үр чадвар.

14.Энэ журмын 11-д зааснаас бусад төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтан /цаашид "удирдах албан тушаалтан" гэх/-ы сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд нь:

а/Төрийн албаны тухай хуулийн

17.1-д заасны дагуу тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, төрийн жинхэнэ албан тушаалд бэлтгэгдсэн байдал, мэргэшлийн түвшингээр нь 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулж, Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн албан тушаал давшуулах замаар уг орон тоог нөхөж болно.

б/энэ журмын 14-ийн "а"-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлийн удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс тухайн албан тушаалд тавих шаардлагыг харгалзан 2-оос доошгүй иргэнийг сонгон шалгаруулж, Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн уг орон тоог нөхөж болно;

в/энэ журмын 14-ийн "а", "б"-д заасны дагуу тухайн орон тоог нөхөх боломжгүй тохиолдолд уг ажлын байранд ажиллах удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах захиалгыг ажлын байрны тодорхойлолтын хамт Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлд ирүүлнэ.

15.Энэ журмын 14-ийн "а", "б"-д заасны дагуу удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулж ажилд томилсон тохиолдолд тухайн албан тушаалтныг ямар шалгуураар томилсон тухайгаа Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлд бичгээр мэдэгдэнэ.

16. Энэ журмын 9, 10, 14-ийн "в"-д заасан удирдах албан тушаалын сул орон тооны захиалгын тоо, ажлын хэргийг шаардлагыг харгалзан сонгон шалгаруулалт явуулах хугацааг Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөл тухайн үед нь шийдвэрлэж байна.

Дөрөв. Сонгон шалгаруулалтыг мэдээлэх

17.Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөл нь энэ журмын 9-ийн "а", 14-ийн "в"-д заасан тохиолдолд сонгон шалгаруулалт явуулахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө тухайн албан тушаалын талаар болон бусад холбогдох мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

18. Мэдээлэлд нэр дэвшигчид тавих болзол, шаардлага, бүрдүүлэх материал, сонгон шалгаруулах комиссын хаяг, харилцах утасны дугаар, материал хүлээн авах, бүртгэх болон сонгон шалгаруулалт явуулах байр, хугацаа зэргийг заана. Мэдээлэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд сонгон шалгаруулах комисс тухай бүрд нь мэдээлж байна.

Тав. Сонгон шалгаруулах комисс байгуулах

19. Удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комисс (цаашид "комисс" гэх)-ыг Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлийн шийдвэрээр комиссын дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Комиссыг Төрийн албаны зөвлөлийн буюу Салбар зөвлөлийн гишүүн ахалж, комиссын бүрэлдэхүүнд тухайн салбарын талаар мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оруулна.

20. Сонгон шалгаруулалт явуулах бүрт комиссыг шинээр байгуулна.

21. Комисс нь сонгон шалгаруулалттай холбогдсон аливаа асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж шийдвэрлэнэ.

22. Комисс дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ нэр дэвшигчийн материалыг хүлээн авч, хянан нэгтгэх;

2/ сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

3/ сонгон шалгаруулалтын дүнг хуралдаанаараа хэлэлцэж, сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргах;

4/ сонгон шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлж байх;

5/ сонгон шалгаруулалт явуулах байр, бусад шаардагдах нөхцөлийг хангах;

6/ сонгон шалгаруулалт явуулсан тухай тайланг тэнцсэн иргэдийн нэрсийн жагсаалтын хамт Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлд ирүүлэх.

23. Комиссын нарийн бичгийн дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ сонгон шалгаруулалттай холбогдсон асуудлаар комиссын даргад өдөр тутам тусалж, холбогдох мэдээллээр хангах;

2/ сонгон шалгаруулалттай холбогдсон санал, хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлүүлж байх;

3/ комиссын хуралдааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, шийдвэрийг нь зохих журмын дагуу баталгаажуулах;

4/ сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлангийн төсөл бэлтгэх;

5/ сонгон шалгаруулалтын материалыг зохих журмын дагуу цэгцэлж архивт шилжүүлэх.

Зургаа. Сонгон шалгаруулалтад оролцогчийг бүртгэх

24. Комисс сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэдээс дор дурдсан материалыг тогтоосон хугацаанд харьяаллын дагуу хүлээн авч бүртгэнэ:

1/ биеийн байцаалт (Төрийн албан хаагчийн биеийн байцаалтын маягт № 1-ийн дагуу);

2/ боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3/ Монгол Улсын иргэний үнэмлэх;

4/ ажил эрхэлдэг бол ажил байдлын тодорхойлолт;

5/ Төрийн албаны тухай хуулийн 16.2.1-д заасан асуудлаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

6/ 4х6-ийн хэмжээтэй 2 хувь зураг.

25. Иргэнийг дор дурдсан тохиолдолд бүртгэхгүй:

1/ энэ журмын 24-т заасан материалыг дутуу бүрдүүлсэн;

2/ Төрийн албаны тухай хуулийн 16.2-т заасан төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол хангаагүй.

Долоо. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

26. Удирдах албан тушаалд ажиллах хүсэлт ирүүлсэн иргэний биеийн байцаалт, холбогдох бусад материалыг Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, журам, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий ба тусгай шаардлагатай харьцуулах замаар эхний шалгаруулалт явуулна.

27. Эхний шалгаруулалтад тэнцсэн иргэдийг дараахь хэлбэрээр сонгон шалгаруулна:

- удирдах ур чадварын түвшин тогтоох;

- ярилцлага хийж;

- эрүүл мэндийн үзлэг.

28. Комисс сонгон шалгаруулалтыг дор дурдсан байдлаар зохион байгуулна:

1/ Төрийн албаны зөвлөл буюу

Салбар зөвлөлөөс тогтоосон өдөр, цагт багтаан удирдах ур чадварын түвшинг тогтоож, ярилцлагыг явуулж, дүгнэх;

2/удирдах ур чадварын түвшинг хангасан, ярилцлагад тэнцсэн иргэнийг магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын үзлэгт оруулж, эрүүл мэндийн дүгнэлт гаргуулах.

Найм. Сонгон шалгаруулалтын дүн гаргах

29. Сонгон шалгаруулалтын дүнг комиссын хуралдаанаар хэлэлцэн зохих шийдвэр гаргана. Комиссын хуралдааны шийдвэрийг 2 хувь үйлдэж, комиссын дарга, гишүүд гарын үсэг зурна.

30. Комиссын дарга сонгон шалгаруулалт явуулсан тухай тайланг сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн нэрсийн жагсаалтын хамт Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлд биечлэн өгнө.

Ес. Нэр дэвшүүлэх

31. Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөл нь сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг судалж, магадлах шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдээс тодорхойлолт гаргуулж болно.

32. Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөл нь комиссын тайланг хуралдаанаараа хэлэлцэж, комиссын санал, өөрийн явуулсан судалгаа, холбогдох этгээдийн тодорхойлолт зэргийг үндэслэн төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, тухайн удирдах албан тушаалд төвөгдөх ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан иргэнийг удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад оруулах тухай шийдвэр гаргана.

33. Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөл нь удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтаас тухайн албан тушаалын шаардлагыг хамгийн сайн хангаж байгаа нэр дэвшигчээс эхлэн дараахь байдлаар нэр дэвшүүлнэ:

а/энэ журмын 9-ийн "а"-д заасан албан тушаал бүрт 3-5 иргэний нэрийг;

б/энэ журмын 9-ийн "б", "в", "г", 10-т заасан албан тушаал бүрт 2-оос доошгүй иргэний нэрийг.

34. Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөл нь энэ журмын 9-ийн "а"-д заасан нэр дэвшигчийн талаархи санал, дүгнэлтээ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.4-д заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж, томилох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ. Бусад нэр дэвшигчийн талаархи санал, дүгнэлтийг томилох эрх бүхий этгээдэд шууд хүргүүлнэ.

35. Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөл нь удирдах албан тушаалд нэр дэвшигчийг хэрхэн сонгосон тухай болон тэдний нэрсийн жагсаалтыг нийтэд мэдээлнэ.

36. Төсвийн байгууллагын удирдлага,

санхүүжилтийн тухай хуулийн 45.5-д заасны дагуу томилох эрх бүхий этгээд Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн иргэдийн дотроос нэг хүнийг сонгож, тухайн албан тушаалд томилсон тухай шийдвэр гаргана.

37. Томилох эрх бүхий этгээд Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлийн санал болгосон нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилохоос татгалзал энэ тухайгаа зохих үндэслэлийн хамт нэр дэвшигчийн материалыг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөл нь тухайн сонгон шалгаруулалтад тэнцэж нөөцийн жагсаалтад орсон иргээдээ нэр дэвшүүлэх, эсхүл сонгон шалгаруулалтыг дахин явуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

38. Сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилохгүй.

Арав. Удирдах албан тушаалтны нөөц бүрдүүлэх

39. Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад оруулах тухай Төрийн албаны зөвлөл буюу Салбар зөвлөлийн шийдвэр 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

40. Удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэлтэй иргэн өмнөх сонгон шалгаруулалтад өрсөлдсөн албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд энэ журмын 39-д заасан хугацааны дотор шууд нэр дэвших эрхтэй. Харин өмнөх сонгон шалгаруулалтад өрсөлдсөнөөс өөр албан тушаалд ажиллахыг хүсвэл сонгон шалгаруулалтад дахин орно.

41. Энэ журамд заасан сонгон шалгаруулалтад тэнцсэн төрийн жинхэнэ албанд анх орох иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 17.3-т заасан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгсөнд тооцно.

Арван нэг. Бусад зүйл

42. Удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахад улс төрийн хүчин, төрийн өндөр албан тушаалтан, төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс Төрийн албаны зөвлөл болон Салбар зөвлөлд нөлөө үзүүлэхийг хориглоно.

43. Төрийн албаны зөвлөл нь энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангана.

44. Удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулахтай холбогдсон асуудлаар гаргасан маргааныг Улсын Их Хурлаас тогтоосон журмын дагуу Төрийн албаны зөвлөл болон Салбар зөвлөлд харьяаллын дагуу хянан шийдвэрлэнэ.



2003 оны 5 дугаар сарын 8-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар 14

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 39.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Улсын Их Хурлын 1995 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 77 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧ, УГ АЛБАН ТУШААЛД НЭР ДЭВШИГЧИЙН ХООРОНД ТӨРИЙН АЛБАТАЙ ХОЛБОГДСОН АСУУДЛААР ГАРСАН МАРГААНЫГ ХҮЛЭЭН АВЧ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг Төрийн албаны зөвлөл, түүний салбар зөвлөлөөр хянан шийдвэрлэхэд энэхүү журмыг баримтлана.

2. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг энэ журмаар тогтоосон харьяаллын дагуу хянан шийдвэрлэнэ.

3. Төрийн албаны зөвлөл нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай дараахь маргааныг хянан шийдвэрлэнэ:

1/Төрийн албаны тухай хуулийн 17.2, 17.3-т заасан төрийн албаны мэргэшлийн шалгалтын талаар төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комисс болон төрийн захиргааны төв байгууллагын мэргэшлийн шалгалтын салбар комисстой холбогдож гарсан маргаан;

2/Төрийн албаны зөвлөлөөс төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилохтой холбогдож гарсан маргаан;

3/Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлэн томилогдсон удирдах албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбогдон гарсан маргаан;

4/Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлэн томилогдсон удирдах албан тушаалтнаас дараахь асуудлаар гаргасан маргаан:

а/төрийн захиргааны тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв, төрийн захиргааны дээрх ангилалтай дүйцэх төрийн

тусгай албаны удирдах албан тушаалын цол, зэрэг дэв олгох асуудалтай холбогдож гарсан маргаан;

б/Төрийн албаны тухай хуулийн 19.2-т заасны дагуу үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, зохио шатны сургалтад хамруулах, цалин хөлсийг өөрчлөх, албан тушаал бууруулах асуудалтай холбогдож гарсан маргаан;

в/мөн хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу захиргааны саназчилгаар албан тушаалаас бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөнтэй холбогдож гарсан маргаан;

г/мөн хуулийн 25 дугаар зүйл, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 47.3-т заасны дагуу төрийн албанаас халсантай холбогдож гарсан маргаан;

д/Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулсантай холбогдож гарсан маргаан;

е/мөн хуулийн 39.1.2-т заасны дагуу ажиллах нөхцөл, цалин хөлс, баталгааны талаар гаргасан бусад маргаан.

5/төрийн албаны салбар зөвлөлгүй төрийн байгууллагын төрийн жинхэнэ албан хаагчаас гаргасан энэхүү журмын 3-ын 1-3, 4-ийн 4-т заасан маргаан;

6/төрийн албан хаагчаас салбар зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн маргаан;

7/салбар зөвлөлийн даргын өөрийнх нь гомдлоор үүссэн маргаан.

4. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай дараахь маргааныг хянан шийдвэрлэнэ:

1/Төрийн албаны тухай хуулийн 17.2, 17.3-т заасан төрийн албаны мэргэшлийн шалгалтын талаар нутгийн захиргааны байгууллагын шалгалтын салбар комисстой холбогдож гарсан маргаан;

2/Төрийн албаны салбар зөвлөлөөс төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилохтой холбогдож гарсан маргаан

3/Төрийн албаны салбар зөвлөлөөс нэр дэвшүүлэн томилогдсон төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбогдож гарсан маргаан;

4/Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс нэр дэвшүүлэн томилогдсон төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтан болон бусад төрийн жинхэнэ албан хаагчээс дараахь асуудлаар гаргасан маргаан:

а/энэ журмын 3-ын 4-ийн "а"-д зааснаас бусад ангиллын албан тушаалын цол, зэрэг дэв олгох асуудалтай холбогдож гарсан маргаан;

б/энэ журмын 3-ын 4-ийн "б" - "е"-д заасан маргаан.

5/Үндэсний аудитын газар, Монголбанк, Үнэт цаасны хороо, Үндэсний статистикийн газрын харьяа орон нутгийн салбар байгууллагуудад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчээс гаргасан энэхүү журмын 4-ийн 1-4-т заасан маргаан.

5.Төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг дор дурдсан этгээдийн гомдлоор үүсгэж болно:

1/Төрийн албаны тухай хуулийн 17.2-т заасны дагуу төрийн албаны мэргэшлийн шалгалтад орох эрх бүхий бөгөөд хүсэлтээ гаргасан иргэн;

2/Төрийн жинхэнэ албан хаагч, мөн хуулийн 17.3-т заасны дагуу явагдсан мэргэшлийн шалгалтад тэнцэж, төрийн албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэн;

3/Төрийн албаны тухай хуулийн 17.4-т заасны дагуу явагдсан шалгаруулалтад хамрагдсан болон удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэн;

4/Мөн хуулийн 35.1.6-д заасан сонгон шалгаруулалтад орсон иргэн;

5/Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45, 48 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нэр дэвшиж томилогдох эрх бүхий иргэн.

6.Төрийн албаны тухай хуулийн 17.10-д заасан үндэслэлээр төрийн захиргааны албан тушаалд түр томилогдсон иргэн, 18.1-д заасан үндэслэлээр туршигтын хугацаагаар ажиллаж байгаа албан хаагчийг

ажлаас халсантай холбогдож гарсан маргаан энэ журманд хамаарахгүй.

Хоёр: Гомдлыг хүлээн авах, шалгах

7.Энэ журмын 5-д дурдсан этгээд нь төрийн албатай холбогдсон асуудлаар гаргах гомдлоо мөн журмын 3, 4-т заасан харьяалтын дагуу бичгээр ирүүлнэ.

Гомдолд маргаан үүсэх болсон үндэслэл, шалтгааныг тодорхой дурдаж, өөрийнхөө тавьж буй шаардлагын талаархи нотолгоо, бусад холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргаж болно.

8.Төрийн албаны зөвлөл, түүний салбар зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) гомдлыг хүлээн авмагц дараахь ажиллагааг явуулна:

1/энэ журмын 3, 4-т заасан харьяалтын бус болон эрх бүхий байгууллагаар шалгуулах, хянуулах шаардлагатай гомдлыг зохих байгууллагад ажлын 5 өдрийн дотор шилжүүлж, энэ тухай гомдол гаргагчид бичгээр мэдэгдэх;

2/хүлээн авч шийдвэрлэх эрх зүйн үндэслэлтэй гэж үзвэл маргааныг хянан шалгах хомисс /цаашид "комисс" гэх/-ыг ажлын 5 өдрийн дотор байгуулах.

9. Маргааны шинж байдлыг харгалзан Зөвлөлийн дарга уг комиссыг 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, тухайн Зөвлөлийн аль нэг гишүүнээр даргалуулна. Гомдлыг хянан шалгах ажлыг комиссын дарга хариуцан зохион байгуулна.

10.Комиссын бүрэлдэхүүнд Төрийн албаны зөвлөлийн гишүүн, ажлын албаны ажилтан, тухайн салбар зөвлөлийн гишүүн, түүнчлэн төрийн захиргааны болон бусад байгууллагаас төрийн албаны ажлын туршлагатай, мэргэшсэн албан хаагчийг оролцуулж болно.

Харин комиссын бүрэлдэхүүнд гомдол гаргагчийн маргаанд холбогдох албан тушаалтны болон гомдол гаргагчийн төрөл садангийн этгээдийг оролцуулахгүй.

11.Маргагч талууд комиссын бүрэлдэхүүнийг татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд тодорхой үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр гаргаж, Зөвлөлийн даргад өгнө. Хүсэлттэй холбогдсон асуудлыг Зөвлөлийн дарга хянан үзэж шийдвэрлэнэ.

12.Комисс нь маргааныг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шалгалтыг явуулж дуусгах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн даргын шийдвэрээр хугацааг дахин 30 хүртэл хоногоор сунгаж болно.

13.Комисс нь маргаанд холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтантай уулзаж, тэдний тайлбар, санал дүгнэлтийг сонсох, маргааныг шийдвэрлэхэд шаардагдах материал, баримт бичгийг холбогдох албан тушаалтан, төрийн жинхэнэ албан хаагч, түүнчлэн гомдол гаргагч иргэнээс гаргуулан авч танилцах эрхтэй.

14. Комисс нь маргааныг хянан шалгахдаа дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/маргааныг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацааны дотор, шударга, шуурхай шалган шийдвэрлэх;

2/маргааныг хянан шалгасан дүнг хуралдаанаараа хэлэлцэж, комиссын гишүүдийн олонхийн саналаар дүнгэлт гаргах; Энэхүү дүнгэлт нь аливаа албан тушаалтан, улс төрийн хүчний нөлөөлөлд автаагүй, нотлох баримтад үндэслэгдсэн байна. Комиссын дүнгэлттэй эсрэг саналтай гишүүний саналыг Зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

3/дүнгэлтээ Зөвлөлийн хуралдаанд оруулах.

Гурав. Маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаа

15. Төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хянан шалгасан комиссын дүнгэлтийг Зөвлөлийн хуралдаанаар хянан хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Зөвлөлийн гишүүд болон комиссоос санал болгосон тохиолдолд маргагч талуудыг хуралдаанд оролцуулж, тэдэнд дүнгэлтийн талаар тийлбар хийх, өөр хоорондоо мэтгэлцэх бололцоог олгоно.

16. Зөвлөл дүнгэлтийг хэлэлцээд, тогтоол гаргах, эсхүл дахин шалгуулахаар комисст буцаах шийдвэр гаргана.

17. Зөвлөл нь дараахь үндэслэлээр гомдлыг дахин шалгуулахаар комисст буцаах шийдвэр гаргаж болно:

1/шийдвэр гаргахад нотолгоо болох баримт бичгийн бүрдэл хангагдаагүй;

2/маргаанд холбогдох баримт бичиг, бусад материалыг шалгаагүй буюу хангалтгүй шалгасан.

18. Зөвлөл гаргасан шийдвэрээ ажлын 10 өдөрт багтаан маргагч талуудад мэдэгдэх бөгөөд Зөвлөлийн гаргасан тогтоолыг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

19. Төрийн байгууллага болон төрийн жөхжэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хянан шийдвэрлэсэн тухай салбар зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн албаны зөвлөлд, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдлоо гаргаж болно.

20. Төрийн албаны зөвлөл нь салбар зөвлөлийн шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

"Алтанбулаг" Худалдааны чөлөөт бүсийн хилийн заагийг өөрчлөн батлах тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн хилийн заагийг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

"Хилийн зааг тогтоох тухай" Улсын Их Хурлын 1996 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 66 дугаар тогтоолын хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Улсын Их Хурлын 2003 оны 15 дугаар тогтоолын хавсралт

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН НУТАГ ДАХЬ "АЛТАНБУЛАГ" ЭДИЙН ЗАСАГ ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХИЛИЙН ЗААГ

Алтанбулаг боомтын шалган нэвтрүүлэх цогцолборын хашааны зүүн хойт өнцгийг 1 шон болгон авч зүүн тийш 761 м явж II шон, II шонгоос зүүн хойт чиглэлд Бүрэг уулын энгэр рүү 1750 м явж III шон, III шонгоос зүүн тийш 1200 м явж IV шон, IV шонгоос урагш эргэж 1000 м явж V шон, V шонгоос зүүн тийш 2550 явж, VI шон, VI шонгоос зүүн урагш чиглэлд Долоон давааны баруун талаар гарч Агит ухаагийн хажуу руу 1950 м явж VII шон,

VII шонгоос баруун урагш чиглэлд 2850 м явж VIII шон, VIII шонгоос хойшоо эргэж 965 м явж IX шон, IX шонгоос эгц баруун чигт гэр хорооллын араар 1550 м явж X шон, X шонгоос эгц хойш эргэж 1260 м явж булагын зүүн хойт эхэнд XI шон, XI шонгоос эгц баруун тийш шалган нэвтрүүлэх цогцолборын хашааны зүүн булан хүртэл 761 м явж XII шон, XII шонгоос хашааны дагуу зүүн хойт өнцөг хүртэл явж 1 шон явж хиллэнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

төсөл, угсралт, засвар үйлчилгээ, тавилга, техник, тоног төхөөрөмж, материал, программ хангамж.

"Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 122 дугаар тогтоолын хавсралтад дор дурдсан агуулгатай Ү хэсэг нэмсүгэй:

2. Төрийн ордны аюулгүй байдлыг хангах зориулалттай дохиолол, хамгаалалтын тусгай техник хэрэгсэл, программ хангамж, засвар үйлчилгээ."

"Ү. Тусгай зориулалтын барилга байгууламж

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

1. Төрийн ордон, Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Төрийн харш, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууц болон хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын барилга байгууламжийн зураг

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тухай" Сайд нарын Зөвлөлийн 1967 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 316 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Прага хотноо 1966 онд байгуулсан БНМАУ-ын Засгийн газар, БНСЧУ-ын Засгийн газар хоорондын Ургамлын хортон, өвчин, хог ургамлаас хамгаалах болон хорио, цэврийн талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр хүчингүй болсонд тооцсонтой холбогдуулан "Ургамлын хортон, өвчний талаар хамтран ажиллах хэлэлцээрийг батлах

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН
САЙД

Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

нарийн бичгийн даргын албан тушаалд тус тус томилсугай.

1. Өөр ажилд шилжих болсонтой холбогдуулан Баасанжавын Ганболдыг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын, Намжилын Түмэндэмбэрэлийг Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын, Пунцагдоржийн Дамдиндоржийг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН
САЙД

Л.ЭРДЭНЭЧУЛУУН

ГАДААД ХЭРГИЙН САЙД
БӨГӨӨД САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ЭРДЭНЭЧУЛУУН

2. Раднаабазарын Алтангэрэлийг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын, Чимэдийн Хүрэлбаатарыг Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын, Нанцагийн Батсуурийг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД

Д.НАСАНЖАРГАЛ

2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ /ХОЙШИД ИХШХШ ГЭХ/ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗААЛТ ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүн В.Удвал, Ц.Сарантуяа, Ч.Дашням, Л.Рэнчин /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяа нарыг оролцуулан, Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд хийв.

Хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Оюунбаатар, Б.Баттулга, өргөдөл гаргагч иргэн Н.Хайдав нар оролцлоо.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, ТЕГ-ын 50-2-24 тоотод оршин суух иргэн Н.Хайдав Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"1.2002 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуулийн 31 дүгээр зүйл 31.1 заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2; Дөчин есдүгээр зүйлийн 1,2; Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт мөн хуулийн 170 дугаар зүйл 170.3 заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14; Арван есдүгээр зүйл 1, 2 дахь хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.ИХШХШ тухай хуулийн 31.1 заалтад тусгагдсан төрийн ашиг сонирхол гэдэгт хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын байгууллагуудын ашиг сонирхол хөндөгдсөн байж болох ойлголт хэмрагдах бөгөөд эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны талаарх асуудал хөндөгдөж байгаа нь тэдгээрт ажилладаг ажилтан, албан тушаалтан /иргэд/ нарын үйл ажиллагаанаас үүдэлтэй байх нь тодорхой. Тийм нөхцөлд тухайн ажилтан, албан тушаалтан шүүхийн өмнө бусад иргэний адил эрхтэй байхыг Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1,2 дахь хэсгийн заалтаар баталгаажсан бөгөөд үүнд хөндлөнгийн оролцоо байж болохгүйг Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтаар хориглоосон болно.

Төрийн байгууллагын /хэн нэгэн албан тушаалтан/ хүсэлтээр тэдгээрийг төлөөлөн прокурорын байгууллага хөндлөнгөөс оролцох нь

прокурорын хяналтыг үгүйсгэж албан тушаалтны төлөөлөгч болж Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна.

3.ИХШХШ тухай хуулийн 170 дугаар зүйл 170.3 заалтаар иргэний цаашид гомдол гаргах эрхийг хязгаарласан нь шүүх, шүүгчийн гаргаж болох /хуулийг буруу хэрэглэсэн, бусдын нөлөөнд автсан гэх мэт/ алдаатай шийдвэрийг хянах боломжийг хааж иргэдийг хохироох, чирэгдүүлэх нөхцлийг бий болгож байна. Ийнхүү хүний эрхийг хязгаарлаж буй нь шүүхийн анхан шатанд иргэний зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, итгэл үнэмшилтэй байх, цаашид төрийн байгууллага /шүүх/, албан тушаалтанд хандах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах зэрэг Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх боломжгүйд хүргэн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14; Арван есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1, 170 дугаар зүйл 170.3 заалтуудыг хянан үзэж хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

Иргэн Н.Хайдав уг өргөдлийнхөө дагуу гаргасан нэмэлт тодотгоол, тайлбартаа:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /ИХШХШ/ Монгол Улсын хуулийн 31 дүгээр зүйл 31.1 "Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасныг дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэж заасныг Прокурорын байгууллагын тухай Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйл 16.1 "Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохиогчийн төлөөлөгчөөр оролцох, өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэнэ", 16.2 "Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцоходоо ИХШХШ хуулийн 25, 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ", 16.6 "Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах эрхгүй" хэмээн зааж баталгаажуулсан байна.

Миний бие Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөх улс нийгмийн /төрийн/ өмч хөрөнгөнд багагүй хохирол учрах зэргээр хууль зөрчигдөх нь төрийн ашиг сонирхол хохирох гэсэн ойлголтонд хамрагдана гэж үзэж байгаа бөгөөд прокурорын байгууллага, прокурор аль нэг байгууллага албан тушаалтны хүсэлтээр тэдгээрийг төлөөлөн өмгөөлөн хамгаалах үүрэгтэйгээр бус харин иргэдийнхээ зөрчилдсөн эрхийг сэргээх, улс нийгэмд учирсан хохирлыг арилгуулах гэх мэт хуулийн зөрчлийг таслан зогсоох зорилгоор төрийн нэрийн өмнөөс нэхэмжлэгчээр оролцож болохыг үгүйсгэхгүй байгаа болно.

Дээрх хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн прокурор төрийн байгууллагын /албан тушаалтан/ хүсэлтээр тухайн байгууллагыг төлөөлөн өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэн оролцох нь ИХШШ хуулийн 36 дугаар зүйл 36.5.3 "Өөрөө иргэнийхээ хувьд түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар буюу ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд ...прокурор ..." оролцож болохгүй гэсэн заалттай зөрчилдөж байгаагийн зэрэгцээ хууль хяналтын байгууллагаар төлөөлүүлэх, өмгөөлөн хамгаалуулах давуу эрхийг төрийн байгууллага /албан тушаалтан/-д олгож байгаа нь Үндсэн хуулийн Арав дөрөвдүгээр зүйл 1.2 "хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаарлан гадуурхахгүй байх", Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 "гэр, ...бусад байгууллагын албан тушаалтан иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий хууль хяналтын байгууллага мөний хувьд иргэний хэрэгт маргалдагч талуудын нэгний нь /төрийн байгууллага, албан тушаалтны/ эрх ашгийг хамгаалан өмгөөлөгчийн бүрэн эрхтэйгээр оролцуулахаар хуульд заасан нь прокурорын зүгээс хяналтын үүргээ биелүүлэх боломжгүй болж Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчиж байна.

Дээрх байдлаас дүгнэн үзээд Үндсэн хуулийн Арав дөрөвдүгээр зүйлийн 1.2; Дөчин есдүгээр зүйлийн 2; Тавьдугаар зүйлийн 1 дэх заалтуудыг зөрчсөн ИХШШ хуулийн 31 дүгээр зүйл 31.1 прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйл 16.1, 16.2, 16.6 заалтуудыг тус тус хүчингүй болгох өгнө үү.

2.ИХШШ тухай хуулийн 65 дугаар зүйл 65.1 "шүүхэд харьяалагдахгүй", 65.1.6 "...нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан..."

гэсэн заалтууд нь мөн хуулийн 10 дугаар зүйл 10.6 "Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй буюу байгаа нь тодорхой бус гэсэн үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзаж болохгүй", 65.1.3 "шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал" гэсэн заалтуудтай давхардан зөрчилдөг эдгээрээс өөр шүүхэд ул хамааран, шүүхээс өөр байгууллагаар шийдвэрлүүлж болох хэрэг маргаан байж болох мэт ойлголтыг агуулж байгаа болон анхан шатны шүүхээс нэхэмжлэл, гомдлыг хүлээн авахаас хууль бусаар татгалзан гэж үзэж хянуулан засуулах хүсэлтэй байгаа нэхэмжлэгч гомдол гаргагчийн эрхийг хязгаарлан байгууллага, иргэдийг чирэгдүүлэн хохирох, хэрэг маргаан шийдэгдэхгүй байж болохоор байгаа юм.

Иймээс ИХШШ тухай хуулийн 65.1.1 заалт, 65.1.6-ийн "...нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан..." гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арав зургадугаар зүйлийн 12 дахь хэсгийн "Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй", 14 дэх хэсгийн "...шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах..." эрхтэй", Арав есдүгээр зүйлийн 1 "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна", Дөчин долдугаар зүйл "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна гэж үзэж ИХШШ тухай хуулийн 65.1. заалт, 65.1.6 "...нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан...", 170.3 заалтаас 65.1-ийг тус тус хэсч хүчингүй болгуулахаар нэхэмжлэж байгаа болно" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар, Б.Баттулга нар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"1.Прокурорын байгууллагын тухай хуулийн 16.1, 16.2, 16.6, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /ИХШШТХ/-ийн 31.1-д заасан заалт нь төрийн аль нэг байгууллагад хууль хяналтын байгууллагаар төлөөлүүлэх, өмгөөлөн хамгаалуулах давуу эрхийг олгож байна, шүүн таслах ажиллагаанд прокурор хөндлөнгөөс оролцож болно гэсний хувьд:

-Прокурор Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд заасан шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргээ хэрэгжүүлж шүүх хуралд зөвхөн төрийн байгууллагын хүсэлтээр зохигч буюу тэдний төлөөлөгчөөр л, өмгөөлөгчийн

эрхтэй оролцох бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг зохигч нөгөөхөөсөө олон хүн оролцуулснаар давуу тал эдлэхгүй юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэдэн ч өмгөөлөгч оролцож болохыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.1, ЭБШХ-ийн 39.3-д тодорхой заасан юм. Прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцсоноор ямар нэг давуу эрх эдлэх биш зөвхөн өмгөөлөгчийн эрхийг л эдэлнэ. Үүнийг Улсын дээд шүүхийн 2003 оны 2 дугаар сарын 20-ны едрийн 02 дугаар тогтоолд тодорхой тайлбарласан. Эдгээр нь харин ч Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байна гэсэн заалтыг хангаж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр хэрэгжүүлнэ", 26.4-д "зохигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрх эдэлнэ гэж тус тус заасны дагуу шүүх хуралдаан зохигчдын чөлөөтэй мэтгэлцэх зарчим"-аар явагдаж, зохигчид тэгш эрх эдлэх нөхцөл бололцоогоор хангагдаж байна. Прокурор аль нэг талыг төлөөлснөөр шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцож байгаа хэрэг биш. Ингэж оролцсоноороо шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргээ л хэрэгжүүлж байгаа.

Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1-д заасан прокурорын оролцооны тухай заалт нь 36.5.3-д заасан хязгаарлалттай зөрчилдөж байгаа гэж үзэж байгаа бол Үндсэн хуулийн цэцийн хэлэлцэх асуудал биш, Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ дагуу хянан шийдвэрлэх зүйл тул өргөдөл гаргагч Улсын Их Хуралд хандах нь зүйтэй юм.

2.ИХШХШ тухай хуулийн 65.1.1, 65.1.6-д заасан заалтууд нь 10.6, 65.1.3-д заасан заалтуудтай давхардан зөрчилдөж, шүүхээс өөр байгууллагаар шийдвэрлүүлж болох хэрэг маргаан байж болох ойлголтыг агуулж байна гэсний хувьд:

-Энэ хуулийн 3.2-д шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх өөр журмыг хуулиар тогтоож болно гэж заасан нь Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа бөгөөд Хөдөлмөрийн хууль болон Төрийн албаны тухай хуулинд заасан журмууд нэгэнт хэрэгжиж байна.

ИХШХШ тухай хуулийн 170.3-д заасан заалт нь нэхэмжлэлийг хүлээн авахаас хууль бусаар татгалзаж түүнийг нь давж заалдах боломжгүй болгож хэрэг шийдвэрлэгдэхгүй гэсний хувьд:

-Тухайн асуудал шүүхэд харьяалагдахгүй тохиолдолд түүнийг давж заалдах шаардлага гаргахгүй, тэгээд ч хуулийн 65.2-д заасны дагуу

шүүгч захирамждаа уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, шүүх хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгснөөр хүний эрх зөрчигдөх нөхцөл үүсэхгүй.

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг төр энэ үүргээ зөвхөн шүүхээр дамжуулан хэрэгжүүлнэ гэж өрөөсгөл ойлгож болохгүй юм. Маргааныг гагцхүү шүүх л шийдвэрлэнэ гэж ойлгох нь Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж зааснаас өөр ойлголт юм. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтаас ч энэ нь тодорхой харагдаж байна.

Дээрх байдлуудыг харгалзан үзэж Н.Хайдавын өргөдлийг хэрэгсэхгүй болгуулахаар энэхүү тайлбарныг хүргүүлж байна" гэжээ.

Маргааныг Цэцийн хуралдаанаар хянан хэлэлцэх үед талууд урьд ирүүлсэн үндэслэл, тайлбараа дэмжиж мэтгэлцээн явуулж нэмэлт тодотгол, тайлбар өгөөл.
Тухайлбал, өргөдөл гаргагч Н.Хайдаа хуралдаанд хэлэхдээ:

Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар бол прокурор нэг хурал дээр нэг болохоороо өмгөөлөгч болж, нөгөө болохоороо төрийг төлөөлсөн прокурор болж хувираж болохоор тодорхойлсныг би ер ойлгохгүй байна. Прокурор, өмгөөлөгч хоёр аль аль нь Үндсэн хуулийн ууэл баримтлалын суурь дээр төрөөс тогтоосон хууль цаазын үндсэн дээр өөр, өөрийн өвөрмөц эрх, үүргтэй, онцлог статустай. Ингэж хольж болдог юм уу, Нэртэйгээр нь тэгвэл өмгөөлөгч прокурор гэдэг албан тушаал гаргавал яасан юм бэ? Төр гэдэг чинь ерөнхий ойлголт. Тэгэхлээр иргэн төртэй заргалдана гэвэл байгууллагатай л заргалдана гэсэн үг. Тэгээд бас байгууллагатай заргалдана гэдэг чинь "байшинтай" заргалдахгүй, тэр байгууллагын албан тушаалтантай заргалдана гэсэн үг. Ингэхлээр прокурор төрийг өмгөөлж хуралд оролцно гэдэг чинь эдэстээ аль нэг тодорхой албан тушаалтныг өмгөөлнө гэсэн үг. Ингэхээр шүүхийн өмнө очиж байгаа албан тушаалтан, иргэн хоёр тэгш бус байдалтай болж байна. Яагаад гэвэл албан тушаалтан болохоор үнэгүй /хөлс авдаггүй/, бас цол хэргэмтэй, төрийн том албан тушаалтан болох прокуророор өмгөөлүүлдэг, иргэн болохоор хөлс төлж жирийн өмгөөлөгч авдаг. Ийм байж яаж болох вэ?

Нөгөө талаар аль нэг талыг өмгөөлж хуралд орсон прокурор чинь төрийн хуулийн биелэлтэд хяналт тавих үүргээ умартана, ер нь хяналт тавих ёс суртахууны эрхгүй болно. Асуудалд шударга, голчоор хандах нөхцөл ч алга болно. Энэ бол аюултай.

Би өргөдөлдөө дурдсан бүх шаардлага дэмжиж байна. Алийнх нь ч татаж авахгүй. Бүхэлд нь хэлэлцэж шийдэж өгөхийг хүсье гэв.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Оюунбаатар, Б.Баттулга нар хэлэхдээ:

Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлд прокурор өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ гэж заасан нь шүүх хуралд оролцсон прокурор төр гэж давамгайлахгүй, прокурор гэж давамгайлахгүй, хурлын бусад оролцогчдын л нэгэн адил, тухайлбал жирийн өмгөөлөгчийн л нэгэн адил эрхтэй оролцоно гэсэн санаа юм. Энэ нь харин тэгш бус байдлыг бий болгох биш, тийм байдлыг арилгаж байгаа юм. Харин ч прокурорын нэр хүнд, эрх дархыг хумьж байгаа юм. Иймд "шүүхийн өмнө бүгд тэгш" байх Үндсэн хуулийн заалт зөрчөөгүй.

Шүүх хуралд прокурор төрийн нэрийн өмнөөс оролцоно гэж заасан. Тэгэхлээр төрийн байгууллагыг төлөөлнө гэдэг ч Үндсэн хууль зөрчөөгүй. Төлөөлөгчүүд раяж төрийн нэрийн өмнөөс оролцох юм бэ?

ИХШХШ тухай хуулийн 170 дугаар зүйлд байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын гомдол гаргах эрхийг хязгаарласан заалт хийсэн нь буруу биш. Шүүхээс гарч буй шийдвэрийн төрөл, утга агуулгаас үндэслээд давж заалдаад байх шаардлагагүй олон зүйл бий. Тэднийг л 170 дугаар зүйлийн 3-д нэрлэсэн. Иймд үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл муутай гэлээ.

Маргааныг хянан хэлэлцээд гаргасан дүгнэлтийн үндэслэл:

1.ИХШХШ тухай хуулийн 170 дугаар зүйлийн 3-д шүүхээс нэхэмжлэлийг хянах явцад гаргасан зарим тогтоол, захирамжийг давж заалдах гомдол гаргаж болохгүйгээр хуульчлан заажээ. Тухайлбал, Арбитрт харъяалагдах хэрэг байна гэж буцаах /20.2/; нотолгооны ач холбогдолгүй хамааралгүй, эсвэл нууцад хамаарагдах зүйл гэж баримт сэлтийг нотлох баримтаас сахах, шаардан авахаас татгалзах /38.9/; шүүхэд болон тухайн шүүхэд харъяалагдахгүй гэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.1, 65.1.2/; шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам зөрчсөн гэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.3/; тухайн асуудлын талаар урд нь шүүх арбитрын шийдвэр гарсан гэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.6/; маргаж байгаа зүйлийн талаархи хэргийг өөр шүүхэд шийдвэрлэж байгаа, тухайн асуудлыг эрүүгийн журмаар шалгаж байгаа, хариуцагчийн хаяг тодорхойгүй, хариуцагч иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан гэдэг үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас

татгалзах /65.1.7, 65.1.8, 65.1.9, 65.1.10/ зэрэг тогтоол захирамжийг давж заалдахгүй гэж хуульчилсан нь шүүх, шүүгч эдгээр асуудлаар алдах ёсгүй, цаашид дахин ярих шаардлагагүй гэсэн утга аястай болжээ. Гэтэл алдаагүй, ямагт зөв шийддэг асуудал гэж байдаггүй.

Нөгөө талаар шүүхийн ямар ч шийдвэрийг зохигчид хэрэв хүсвэл давж заалдах, дахин хянуулах зарчим зохигчдын хувьд үргэлж нээлттэй байх учиртай. Энэ нь шударга шүүхийн үйл ажиллагааны гол нөхцөл юм. Чухамхүү давж заалдах зарчим чөлөөтэй хэрэгжсэнээр шүүхийн шийдвэрийн үнэн зөв байх нөхцөл бүрэлдэнэ. Энэ ч учраас Монгол Улсын Үндсэн хуульд иргэд асуудлаа "шударга шүүхээр шүүлгэх", "шүүхийн шийдвэрийг давж заалдах" гэсэн ойлголтуудыг иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөний томоохон үзүүлэлт болгож оруулсан гэж үзэж болно. Энэ үүднээс авч үзвэл өргөдөл гаргагчийн эдгээр асуудлын талаар гаргасан хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй байна.

2.Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д прокурор иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо "Өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ" гэж заасан нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Учир нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд прокурорын үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тоочиж тодорхойлсон. Тухайлбал энд зааснаар прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох л үндсэн эрх үүрэгтэй гэж ойлгож болно. Тэгэхлээр "Өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ" гэсэн нь Үндсэн хуульд томъёолсон прокурорын эрхийг хэт өргөжүүлэн үндэслэл муутай тайлбарлаж хуульчилсан байна. Прокурор шүүх хуралд оролцохдоо прокурорынхоо л эрх үүргийг оролцогчийн хувьд эдлэхээс биш /оролцогчийн эрх үүрэг буюу ИХШХШ тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх үүргийг эдлэх гэдэг нь нээлттэй бөгөөд энэ тухай прокурорын байгууллагын тухай хуулинд ч заагчлан байгаа/ аль нэг өөр оролцогчийн, тухайлбал өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэх нь зохимжгүй юм. Учир нь ИХШХШ тухай хуулийн 25 дугаар зүйлд хуралд оролцсон прокурор хэрэгтэй байж болох бүх эрх, үүрэг хуульчлагджээ. Мөн Прокурорын байгууллагын тухай хуулийг тайлбарласан Дээд шүүхийн 2003 оны 2 дугаар сарын 20-ны 2 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 3-д "Өмгөөллийн тухай хуулийн 16.3 дугаар зүйлд прокурор ажлаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон тул прокуророор ажиллаж байх үедээ Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан өмгөөлөгчийн бүрэн эрхийг эдлэхгүй" гэж заасныг энд анхаарч үзэх нь зүйтэй байна.



3. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16-ийн 6-д: "Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах эрхгүй" гэж заажээ.

Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралд оролцоно гэж заасан нь прокурорын үйл ажиллагааны нэг гол чиг үүргийг тодорхойлжээ. Иймээс энэ чиг үүргийг биелүүлэхээс татгалзаж болохгүй тухай прокурорын хуульд тодотгож заасныг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх боломжгүй байна.

4. ИХШХШ тухай хуулийн 65 дугаар зүйлийн 1, 65 дугаар зүйлийн 1, 6-д зааснаар шүүгч иргэний нэхэмжлэлийг хянаж үзээд тухайн нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх асуудал шүүхэд харъяалагдахгүй буюу эсвэл уг асуудлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж урьд нь гарсан байвал хүлээн авахаас татгалзах тухай захирамж гаргаж шийдвэрлэх нь буруу биш. Учир нь:

а/ шүүхэд харъяалагдахгүй асуудал, гомдол, санал гэж байдаг бөгөөд бүх зүйл, маргаан бүр зөвхөн шүүхээр хэлэлцэгдэн шийдвэрлэгдэх ёстой гэж үзэх боломжгүй. Монгол Улсын Үндсэн хуульд заасан "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн нь маргасан, эргэлзсэн, гомдсон бүх зүйлийг шүүхээр "таслаж өгнө" гэсэн ойлголт биш юм.

б/ тухайн тодорхой нэхэмжлэлийг урьд нь хүлээж авахаас татгалзсан захирамж байгаад тэр нь хүчин төгөлдөр байгаа үед хүлээж авахаас татгалзах захирамж дахин гаргах нь иргэний өргөдөл гомдлыг шүүх ерөөсөө авч хэлэлцэхгүй орхиж байгаа хэрэг биш бөгөөд авч үзээд хуулийн дагуу шийдэж байгаа нэг хэлбэр юм. Нэхэмжлэлийг "хүлээн авахаас татгалзах" гэсэн нь байцаан шийтгэх ажиллагааны өвөрмөц хэллэг /томъёолол/ болохоос биш "шүүхийн хаалгаар битгий оруул" гэх маягтай утга биш юм. Иймээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай шүүгч захирамж гаргаж байгаа иргэний төрийн байгууллагад гомдол гаргах Үндсэн хуулийн эрхийг хязгаарлаж байна, төр иргэдийн гомдлыг шийдвэрлэх Үндсэн хуулийн үүргээ биелүүлээгүй байна гэж ойлгож болохгүй. Иймд энэ асуудлын талаар гаргасан өргөдөл гаргагчийн хүсэлтийг хүлээн авах үндэслэлгүй байна гэж үзлээ.

5. ИХШХШ тухай хуулийн 170 дугаар зүйлийн 3-д заахдаа: энэ хуулийн ... 74, 75, 76, 106.5 дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид зохигч гомдол гаргаж болохгүй гэсэн нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн гэх үндэслэл харагдахгүй байна. Учир нь эдгээр зүйл нь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааг зохицуулсан бөгөөд хэргийн зохигчид буюу гол оролцогч нэхэмжлэгч, хариуцагчид эвлэрсн хэлэлцэж, тохирсон тохиолдолд гарах тогтоол, захирамжийн тухай заажээ. Нэгэнт зохигчид бүгд эвлэрч тохирсон, хариуцагч үүргээ сайн дураараа биелүүлсэн бол шүүхийн энэ эвлэргийг баталгаажуулсан тогтоол шийдвэрийг давах асуудал гарахгүй бөгөөд тэгэхээр аливаа хууль, тэгэх тусмаа Үндсэн хууль зөрчсөн асуудал энд яригдах учиргүй нь ойлгомжтой байна.

ИХШХШ тухай хуулийн 170 дугаар зүйлийн 3-д: энэ хуулийн ... 129, 130 дугаар зүйлүүдэд заасан тогтоол, захирамжид гомдол гаргаж болохгүй гэжээ. 129, 130 дугаар зүйлд шүүх гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг хуульчилж өгсөн байна. Энэ нь хэргийг эцэслэн шийдэж байгаа биш, шийдэхийн өмнө насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх, зохигчдын эвлэрлийн талаар хугацаа заах гэх мэт цаг алдалгүй авах зарим арга хэмжээг заажээ. Энэ нь түр арга хэмжээ бөгөөд хэргийг эцэслэн шийдвэрлэснээр дуусгавар болдог учир давж заалдаад байх шаардлагагүй юм. Иймд энд шүүхийн шийдвэрийг давж заалдах иргэний Үндсэн хуулийн эрх зөрчигдсөн байна гэж үзэх үндэслэлгүй байна.

6. ИХШХШ тухай хуулийн 31.1-д: "Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэж заасан нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн гэж үзэх үндэслэл байхгүй байна. Учир нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд тодорхойлсон "Прокурор... шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэн нь эрүү, иргэний болон бусад шүүх хуралд оролцож болохыг тодорхойлсон байна.

7. Үндсэн хуульд шүүх хуралд "Төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэн нь нэгэн утгаараа төр, түүний байгууллагыг төлөөлнө гэсэн үг гэж ойлгон тайлбарлаж болохоор байна. Төр, түүний эрх ашиг нь төрийн тодорхой байгууллага, тэдгээрийн эрх ашгаар илэрдэг гэсэн хууль цаазын утга зохиолд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн томъёолол байдлийг тэмдэглэх хэрэгтэй.

Иймд Прокурорын байгууллагын тухай хуулийн 16-ийн 1-д заасан прокурор төрийн байгууллагын төлөөлөгчөөр оролцоно гэсэн нь Үндсэн хууль зөрчиж байна гэж үзэх боломжгүй байна.

Иймд дээр дурдсан зүйлүүдийг үндэслэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32, 33 дугаар зүйлүүдийг удирдлага болгон

ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. ИХШХШ тухай хуулийн 170 дугаар зүйлийн 3-д заасан "энэ хуулийн 2.2; 38.9; 65.1.1; 65.1.3; 65.1.6-65.1.10 дахь ...зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-д заасан "Монгол Улсын иргэн... шударга шүүхээр шүүлгэх, ...шүүхийн шийдвэрийг давж заалдах...эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан "...Өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2-д заасан "Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн ...34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ" гэсэн заалтууд Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн заалтыг зөрчсөн байна.

3. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16-ийн 6-д заасан: "Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос прокурор татгалзах эрхгүй" гэсэн заалт нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийг зөрчөөгүй байна.

4. ИХШХШ тухай хуулийн 65 дугаар зүйлийн 1-ийн 1-д заасан "Шүүхэд харъяалагдахгүй", 65 дугаар зүйлийн 1-ийн 6-д заасан "...эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан..." гэсэн заалтууд нь Үндсэн хууль зөрчөөгүй байна.

5. ИХШХШ тухай хуулийн 170 дугаар зүйлийн 3-д заасан "Энэ хуулийн ...74, 75, 76 дугаар зүйл, 106 дугаар зүйлийн 5; 129; 130 дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид зохигч гомдол гаргахгүй" гэсэн заалт нь Монгол

Улсын Үндсэн хуулийн заалт зөрчөөгүй байна.

6. ИХШХШ тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-д заасан "прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэн заалт Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй байна.

7. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан: "Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцоно..." гэсэн заалт; мөн зүйлийн 2-д заасан "Прокурор энэ хуулийн 16-ийн 1-д заасан ажиллагаанд оролцохдоо иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ" гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

8. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА	Н.ЖАНЦАН
ГИШҮҮД	Л.РЭНЧИН
	Ч.ДАШНЯМ
	В.УДВАЛ
	Ц.САРАНТУЯА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛИЙН "ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БҮТЭЦ" ГЭСЭН ОЙЛГОЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.4 дэх заалтыг баримтлан Монгол Улсын Дээд Шүүхээс ТОГТООХ нь:

хэсэгт заасан "тайван цагт ерөнхий зориулалтын, хилийн, дотоод цэрэг"-ийг хамааруулан ойлгохыг тайлбарласугай.

1. "Зэвсэгт хүчний тухай Монгол Улсын хууль"-ийн Хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлийн "Зэвсэгт хүчний бүтэц" гэдэгт мөн зүйлийн 6.2 дахь

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧ

Ч. ГАНБАТ
М. ДАМИРАНСҮРЭН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэл хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 3

☎ 329487